Цагдаагийн дарга нарыг нэг дор цуглуулах боломж тэр бур байдаггүй тул цагдаагийн удирдах ажилтнуудын цугларалтын хөтөлбөрт ХСИС-ийн Удирдлагын сургуулийн сургалтын хөтөлбөр. хичээлийн сэдвээс оруулж сургалтыг явуулах нь удирдах алба хаагчийг хөгжих, мэдлэг чадвараа дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

*ЦЕГ-ын ОНАБХГ-ын Хамгаалалтын газрын*
*Төрийн хамгаалалтын хэлтсийн дарга,*
*ХСИС-ийн докторант,*
*цагдаагийн дэд хурандаа Н.Баярмагнай*

## НИЙТИЙГ ХАМАРСАН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДЛЫГ ТАСЛАН ЗОГСООХ ТУСГАЙ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ ТҮҮНД АЛБА ХААГЧИЙГ БЭЛТГЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Аливаа ажлын төлөвлөлт нь тухайн ажил, үйлчилгээг бага хүч, зардал гарган богино хугацаанд, зөв, оновчтой хийх гүйцэтгэлийн эх суурь болдог.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3. дах хэсэгт улсын дотоод аюулгүй байдлыг “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгуулалыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төловшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн[1]" гэж тодорхойлжээ.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах олон талт, нарийн төвөгтэй ажлыг Монгол Улсын цагдаагийн байгууллага хуулиар олгогдсон эрх, үүргийн хэмжээнд хариуцан гүйцэтгэж байна.

2014 оноос мөрдөж эхэлсэн “Цагдаагийн албаны тухай” Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлд “Цагдаагийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд дор дурдсан эрх хэмжээг хэрэгжүүлнэ” гэж заасан байна. Үүнд:

1.1.3. нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах;

11.1.6. нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалт хийх;

[1] Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Цахим эх сурвалж холбоос: http://www.nsc.gov.mn

11.1.7. эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэх[1]" гэж заасан нь цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг болохыг тодорхойлсон байна.

Нийтийн хэв журмыг сахиулах үйл ажиллагааг хууль тогтоомж, зан заншил. ёс суртахууны шаардлагын алинаар нь ч тогтоосон байж болох боловч цагдаагийн байгууллагын алба хаагч нь зөвхөн хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг хуульд заасан хүч, арга. хэрэгслийг ашиглан сахиулах үүрэгтэй[2].

Эндээс дүгнэж үзвэл төрийн ялангуяа цагдаагийн байгууллагын өмнө нийтийн хэв журам хамгаалахын зэрэгцээ олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг нэгэн адил тавигдаж байна.

Нийтийн эмх замбараагүй байдлыг даамжруулахгүй байх түүнийг аль болох хохирол багатайгаар таслан зогсоох арга барил эзэмших нь алба хаагч бүрийн үүрэг байх ёстой. Үүний тулд нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох тусгай ажиллагааны төлөвлөлтийг хэрхэн хийх, юуг анхаарах талаар авч үзэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Нөхцөл байдлыг тал бүрээс нь сайтар задлан шинжилсний дараа бодитой оршин буй аюулыг өөрчлөх үйл ажиллагааны шинж чанарыг хамгийн сайн тусгасан аль нэг хувилбарыг сонгон авна. Аюулыг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохиролын хэмжээ, далайцыг багасгах зорилготой энэхүү загварыг төлөвлөгөө гэж нэрлэх бөгөөд бичмэл, зурмал аль нэг хэлбэрээр материаллаг хэлбэрт шилжиж бэлэн болдог[3]".

Төлөвлөлтийг хэд хэдэн хувилбараар хийдэг ч түүнийг хэрэгжүүлэх чадвар, чадавхийг алба хаагчдад эзэмшүүлэх нь юу юунаас чухал байна.

Түүнчлэн төлөвлөлтийг хийхдээ харгалзан үзэх ёстой чухал шалгуурүудыг орхигдуулж байгаа жишээ баримтууд ажиглагдаж байна.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед үүрэг гүйцэтгэх нь энгийн нөхцөлд хэв журам хамгаалах, эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэхээс илүү их ажлын ачаалал, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилт, үйл ажиллагааны нарийн боловсруулсан төлөвлөлтийг шаарддаг.

Төлөвлөлт хэдий чинээ бодитой, тодорхой хийгдсэнээс тухайн ажиллагааны эцсийн үр дүн хамаарна.

Нийтийн эмх замбараагүй байдал, гамшиг. ослын үед цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөлт нь үлгэрчилсэн буюу үйл

[1] Цагдаагийн албаны тухай Монгол Улсын хууль. Цахим эх сурвалж, холбоос http://www.legalinfo.mn/law/details/9288

[2] Цагдаагийн ерөнхий газар. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 400.-УБ„ 2010.

[3] *Ж.Бор, В.Чулуунбат.* Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. - УБ., 2012. 88 дах тал.

ажиллагааны, алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйг бэлдэх гэсэн хоёр үндсэн төрөлтэй байна.

Төлөвлөлтийг хийхдээ гадаад, дотоод /өөрийн болон эсрэг талын/ нөхцөл байдлыг бодитоор үнэлэх шаардлагатай ба энэ үнэлгээг буруу хийх нь ихээхэн хохирол гарах үндэс болно.

Дотоод хүчин зүйлийн үнэлгээнд өөрийн байгууллагын хүч. хэрэгсэл, түүнийг байршуулах. сэлгэх, ашиглах зэвсэг, тусгай хэрэгсэл, техникийн боломжууд багтдаг бол гадаад хүчин зүйлийн үнэлгээнд жагсаал, цуглаан, эмх замбараагүй байдлыг зохион байгуулагч, өдөөгч, турхирагч, дэмжигч, сонирхогчдын тоо, тэдний зорилго, хүсэл эрмэлзэл, үзүүлж буй эсэргүүцэл, цаг хугацаа, байршил, зэвсэглэл зэргийг тооцон үздэг.

Үнэлгээг хийхдээ гадаад, дотоод хүчин зүйлийг харьцуулан судлаж, сул болон давуу талуудыг үнэлж, үүссэн бодит байдлыг тооцон хүч хэрэглэхгүйгээр таслан зогсоох, арга үндэслэл, хэлэлцэх, зөвшилцөх нөхцөл бололцоог тодорхойлж байх нь нэн чухал юм.

Үүний зэрэгцээ хариуцсан нутаг дэвсгэртээ хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд анхаарлаа сулруулж болохгүй бөгөөд түүнийг хэрхэн зохион байгуулах талаар тусгайлан төлөвлөж болох юм.

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба болон нутаг дэвсгэр, тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь нийтийг хамарсан эмх зэмбараагүй байдал үүсч болзошгүй нутаг дэвсгэр, объектын судалгааг нарийвчлан гаргаж, үнэлэлт, дүгнэлт хийсний үндсэн дээр хамгаалалтын үлгэрчилсэн /ерөнхий/ төлөвлөгөө, зураглалыг урьдчилан боловсруулах шаардлага гардаг. Үүнд:

> Онц байдал зарласан үед ажиллах;

> Гамшгаас хамгаалах;

> Хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, жагсаал, цуглааны үеийн;

> Болзошгүй нөхцөл байдлын үеийн /онц чухал объектын, олон улсын чанартай тэмцээн, уралдаан, урлаг, уран сайхны шоу тоглолт, хууль бусаар байгалийн баялаг олборлох зэргээр нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчих гэх мэт/;

> Улсын баяр наадам, олон улс болон улс, бүсийн чанартай нийтийн арга хэмжээний хамгаалалтын үеийн;

> Нэг, хоёрдугаар зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтын үеийн;

> Нөхцөл байдал хүндэрсэн үед цагдаагийн болон төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг болно.

Төлөвлөгөө, зураглалыг шууд ашиглах “Ажиллагааны", урьдчилсан ажлын загвар хэлбэрээр хийгдсэн “Үлгэрчилсэн буюу ерөнхий” гэж ангилдаг.

Практикт зарим түвшний удирдах албан тушаалтнууд төлөвлөлтийн ялгааг гаргахгүй байх, үл ойшоох байдал ажиглагддаг бөгөөд энэ нь гүйцэтгэлийн үед ихээхэн хохирол учруулна гэдгийг анхаарах ёстой.

Түүнчлэн зарим тохиолдолд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө, зураглалыг ч гаргах шаардлага тавигддаг.

Төлөвлөгөө, зураглалыг тогтмол шинэчлэн тодотгол хийсэн байх шаардлагатай бөгөөд энэ нь бие бүрэлдэхүүн болон удирдах албан тушаалтныг тухайн үйл ажиллагаанд сургаж бэлтгэх. үүрэг гүйцэтгэх дадлага чадвартай болгох, албаны бэлэн байдлыг хангуулахад онцгой үүрэгтэй.

Бие бүрэлдэхүүнийг төлөвлөгөөний дагуу дадлага сургалтанд хамруулж байх нь юу юунаас чухал юм.

Төлөвлөгөө, зураглалд үүсч болзошгүй нөхцөл байдал, зорилго, оролцох хүч /томилгоот бүлэг/, хэрэгсэл /үндсэн болон нөөц/-ийн тооцоо, цаг хугацаа, байршил, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, үндсэн болон нөөц хүчний байршил, холбооны хэрэгслийн ажиллах тор, сүлжээ, дуудлага, хамгаалалт удирдах ажлын хэсэг /Шуурхай удирдлагын штаб/, удирдах албан тушаалтан, алба хаагчдын үүргийг тодорхой тусгана.

Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх үүднээс ажиллах арга, ажиллагааны хэд хэдэн хувилбарыг тооцон боловсруулна.

Төлөвлөгөөг боловсруулах, хянуулах, батлах, хэрэгжүүлэх, дүгнэх, үнэлгээ шинжилгээ хийх зэрэг цикл хөдөлгөөнд байлгах нь дараа дараагийн төлөвлөлтөнд нэн чухал ач холбогдолтой байдаг.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн эцсийн үр дүн нь түүнийг хэрэгжүүлэх алба хаагчдаас шууд шалтгаалах учраас тэднийг нэгэн адил бэлдэх шаардлагатай байдаг.

Төлөвлөгөөнд алба хаагчдад тактик, зэвсэг, тусгай хэрэгсэлтэй харьцах дадлага, чадвар эзэмшүүлэх, бие бялдарын бэлтгэлжилтийг дээшлүүлэх, тэсвэр хатуужил суулгах, удирдлага, өгөгдөх командуудыг мэдэж биелүүлэх хэвшилд сургах тодорхой зүйлийг тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Гэвч үүнд ач холбогдол бага өгч байгаа нь нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед эрсдэл дагуулах нь гарцаагүй бөгөөд үүний нэг жишээ нь бид бүхний мэдэх “Долоон сарын нэг”-ний хэмээх тодотголтой гунигт түүхэн үйл явдал билээ.

Төлөвлөгөөний биелэлтийг тухай бүр удирдлагын болон хамт олны дунд хэлэлцэн ололт амжилт, алдаа дутагдалыг ярилцан дүгнэж, дараагийн төлөвлөлтийг боловсруулахдаа ашиглаж байвал зохино.

Сургалтын хөтөлбөрийн дагуу нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох тусгай ажиллагааны төрөл бүрийн /олон хүнд нөлөөлөх, тээврийн

хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх, өгөгдөх командуудын зэрэг/ сургалтыг тогтмол зохион байгуулах хэрэгтэй байна.

***Алба хаагчиг ажиллагаанд бэлтгэх.*** Нийтийг хамарсан арга хэмжээний үед үүрэг гүйцэтгэх нь ердийн үед үүрэг гүйцэтгэхээс олон дахин их ачаалалтай байх нь тодорхой юм. Хүн ердийн нөхцөлд сэтгэхүйн хэвшмэл арга барилтай байдаг бол гэнэт бий болсон эмх замбараагүй байдлын үед онцгой сэтгэх, зорилгодоо хүрэхийн тулд мэдлэг чадвар, практик, туршлагаа бүтээлчээр ашиглах хэвшмэл бус үйлдлүүдийг хийх шаардлагатай болдог.

Эмх замбараагүй байдлын үед цагдаагийн алба хаагч бие, сэтгэцийн хувьд эрүүл, ажлын чадвараа хадгалж авхаалж самбаатай байх өөрөөр хэлбэл хүчээ зөв оновчтой хувиарлах нь чухал юм.

Хамтран ажиллагсадаа бэртэж гэмтэх, шархдахад тухайн хүний айдас илэрч, сэтгэл зүйн цочролд орох ба оюуны үйлдэл нь саатал ордог байна.

Энэ байдлаас алба хаагчийн өөртөө итгэх итгэл буурч, бусдыг эрсдэлд оруулахад хүргэдэг. Өндөр эрсдэлтэй ажиллагааны явцад хүний физиологи, айдсын тодорхой шинжүүд илрэн гарч байдаг.

Алба хаагчийн энэ айдсын байдлыг өндөржүүлсэн бэлтгэл сургуулилт /тэвчээр, эр зориг шаардсан/-аар хоёрдмол санаагүй, үүргээ бүрэн гүйцэтгэх бие бялдар, сэтгэл зүйг бэлдэхэд төлөвлөлтийн зорилго чиглэх ёстой[1].

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын эхний 30-40 минут эрсдэлтэй үед тооцогддог ба энэ хугацаанд алба хаагчдын биеэ авч явах чадвар, сэтгэл зүйгээ эзэмдэх шинж чанар чухал юм.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед ажиллах цагдаагийн алба хаагчид нь тухайн нөхцөлд үүссэн зөрчлийг эерэгээр шийдвэрлэх, нөхцөл байдалд дасан зохицох чадвартай, даван туулах хатуужилтай, сэтгэл зүйн тогтвортой байдалтай байх шаардлагатай болдог. Үүний тулд бие бүрэлдэхүүнийг сэтгэл зүйн судалгаа, тандалтанд хамруулах, түүний үр дүнгээс хамааруулан ганцаарчилсан болон бүлгийн сургалт тогтмол оролцуулж байвал зохино.

Өнөөгийн бодит байдлаас харвал энэ чиглэлийн сургалт үндсэндээ орхигдсон гэж хэлж болохоор байна.

Сэтгэл зүйн тогтвортой байдал, төлөвшилтийг нэмэгдүүлэхэд дараах 3 үе шат бүхий үйл ажиллагаа явуулах нь зүйтэй[2]. Үүнд:

1. Бэлтгэгдэх;
2. Хэрэгжүүлэх;

[1] Цагдаагийн байгууллагаас 2012 онд Сүүж-Уул дахь сургалт, дадлагын төвд Нийслэлийн цагдаагийн хүрээний байгууллагуудын алба хаагчдад энэ чиглэлээр сургалт зохион байгуулсан нь зохих үр дүнгээ өгсөн байдаг.

[2] Нийгмийн хэв журам хамгаалах алба. Эрх зүйн акт, арга зүйн зөвлөмж. - УБ., 2012.

3. Төгсгөлийн гэсэн үе шатаар явуулна.

***Бэлтгэгдэх үе шат:*** Энэ үед ямар нэгэн үйл ажиллагаа хийх зайлшгүй шаардлагатай болсныг мэдэгдэхээс эхэлнэ. Алба хаагч сэтгэл санаа. бие бялдар, оюун ухаан, эр зориг гэх мэт бүх талаараа онцгой нөхцөлд ажиллахад бэлтгэнэ. Үйл ажиллагаа эхлэх үед алба хаагчид сэтгэл санааны хувьд тайван, анхаарлаа өөр зүйлд сарниулахгүй байх, хурдан шаламгай. овсгоотой байх, хийж буй үйлдлээ бүрэн хариуцах зэрэгт өөрийгөө бэлдэх хэрэгтэй.

Сэтгэл зүйн хувьд бэлтгэлгүй байх нь ноомой, үлбэгэр байдал гаргах, тогтворгүй, хөшүүн болох, сандрах, анхаарал төвлөрөлгүй болох гэх мэт сөрөг үр дагаварыг үүсгэдэг гэдгийг анхаарах хэрэгтэй.

***Хэрэгжүүлэх үе шат:*** Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллаж байгаа алба хаагч өөртөө болон гаргасан шийдвэртээ итгэлтэй байх, ёс суртахууны хувьд тэсвэр хатуужилтай байхыг шаарддаг. Шийдэмгий бус, өөртөө итгэлгүй, идэвхгүй байх нь алдаа гаргах гол үндэс болдог. Эмх замбараагүй байдал үүссэн үед цагдаагийн алба хаагч хэрэгжүүлж буй ажиллагаа, хэрэглэж буй зэвсэг, тусгай хэрэгсэл, өөрийн зүгээс авч буй арга хэмжээндээ эргэлзэх сэтгэл төрснөөс хүний эрхийг дээдлэх зарчим, тушаалыг биелүүлэх хоёр асуудал хоорондоо зөрчилддөг.

***Төгсгөлийн үе шат:*** Эмх замбараагүй байдлын үед хэрхэн ажилласан, гаргасан шийдвэр хэр үр дүнтэй байсан талаар алба хаагчид өөр хоорондоо санал солилцох, дүгнэх үе шат юм.

Алба хаагчид хэвийн орчиндоо эргэн орох, дасан зохицох чадвар нь тухайн алба хаагчийн ажилласан жил, ажлын туршлагаас гадна тухайн үйл ажиллагаанд ямар үүрэг, эрх мэдэлтэй, ямар хугацаагаар, хэр идэвхтэй оролцсон зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаална.

Эмх замбараагүй байдлын эцсийн үр дүн нь тухайн алба хаагчийн сэтгэхүйг өөрчлөн гажуудуулах хэмжээнд хүртэл дасан зохицуулах талтай. Хэт дасан зохицох байдлыг төрөл бүрийн урлаг, спортын арга хэмжээ, сургалт семинар зохиох гэх мэт өөр үйл ажиллагаанд оролцуулах замаар бууруулах боломжтой.

Алба хаагчдийг эмх замбараагүй байдлын дараа тодорхой хугацаагаар амраах, сэтгэцийн байдлыг ажиглах, сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэх, анхаарлыг өөр зүйлд төвлөрүүлэх, алба хаагчдыг магтаж урамшуулах арга хэмжээг хангалттай зохион байгуулах нь зүйтэй.

Алба хаагч үүрэг гүйцэтгэхээр ирэхдээ хувийн бэлтгэлээ бүрэн хангасан байх шаардлагатай байдаг. Энэ нь зөвхөн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын төдийгүй ердийн нөхцөлд үүрэг гүйцэтгэхэд ч ихээхэн ач холбогдолтой байдаг.

**Хувийн бэлтгэл** гэдэгт үүрэг гүйцэтгэх орчны цаг агаар. улирлын байдалд тохирсон хувцас өмсөх, илчлэг сайтай, амин дэмээр баялаг хоол хүнсийг тохируулан хэрэглэх. сайтар унтаж амарсан байх. биеийн эрүүл мэнд үүрэг гүйцэтгэхэд харшлахгүй байх явдлаар тодорхойлогдоно.

Түүнчлэн гэр бүлийн гишүүдтэй таатай уур амьсгалыг бүрдүүлэх, ар гэрийн амьдрал ахуйд шаардагдах өөрөөс шалтгаалах асуудлыг аль болох бүрэн шийдвэрлэсэн байх явдал үүрэг гүйцэтгэхэд нөлөөлнө.

**Албаны бэлтгэл** гэдэгт тухайн алба хаагч үүргээ гүйцэтгэхэд шаардагдах баримт бичиг /албаны үнэмлэх, энгэрийн тэмдэг. тэмдэглэлийн дэвтэр, үзэг, бал, торгуулийн болон эд зүйл түр хураан авах хуудас гэх мэт/, техник, тусгай хэрэгслийг бүрэн хангасан байхыг хамааруулан ойлгоно.

Албаны үнэмлэх, энгэрийн тэмдгийг хувцасны далд хэсэгт товчтой халаасанд хийх эсвэл удирдлагадаа нэгдсэн журмаар хадгалуулах нь зүйтэй. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед үүрэг гүйцэтгэхэд тусгай өмсгөл, тусгай хэрэгслийг бүрэн, зөв хэрэглэх чадвартай байвал зохино.

Тусгай өмсгөл, тусгай хэрэгсэлийг хүлээн авахдаа иж бүрдэл нь бүрэн, ажиллагаа нь шаардлага хангахуйц байгаа эсэхийг нэгбүрчлэн шалгаж хүлээн авна. Хэрэв дутуу буюу ажиллагаагүй бол нэн даруй солиулна.

Тусгай өмсгөлийг дарааллын дагуу зөв өмсөж, шаардлагатай тусгай хэрэгслийг жагсаалтын дагуу авна. Тусгай өмсгөлийг өмсөхдөө хээрийн хувцсан дээр эхлээд шилбэ, өвдгөвч, гуя, цээж, мөр, шууны хамгаалалт, бээлий, хамгийн сүүлд дуулгыг өмсөнө. Хамгаалалтын тусгай өмсгөлийг дарааллын дагуу богино хугацаанд өмсөх ба өвдөг, шилбэ, гуя, тохойвч, цээживчний даруулгыг бүрэн татаж даруулсан байна.

Тусгай өмсгөлийн иж бүрдэл, даруулга дутуу байх нь ажиллагааны үед гэмтэж, бэртэх эрсдэлт нөхцөлийг бүрдүүлдэг гэдгийг анхаарах хэрэгтэй. Тиймээс алба хаагч бүрийг тусгай өмсгөл, тусгай хэрэгслийг бүрэн өмсөж, үүрэг гүйцэтгэх бэлтгэлээ хангасан байхыг шаарддаг.

Хорт утааны багийг өөрт тааруулан авч, үйлдвэрээс гаргасан техникийн засвар үйлчилгээ, ашиглалтын зааврын дагуу агаар сорох төхөөрөмж, шүүлтүүр, дамжуулах хоолойн ажиллагаа бүрэн бүтэн эсэхийг шалгана. Солонгос Улсад үйлдвэрлэсэн хорт утааны багны шүүлтүүрийн ажиллах хугацаа тагийг авсанаас хойш 2 цаг, ОХУ-д үйлдвэрлэсэн хорт утааны багны шүүлтүүрийн ажиллах хугацаа байнгын байдаг. Баг хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгахдаа багийг өмсөөд хэд хэдэн удаа гүн амьсгаа авах ба амьсгалахад хүндрэлтэй байвал ашиглаж болохгүй. Хорт утааны багыг зүүн талдаа зүүнэ. Болзошгүй аюулын үед хэрэглэх гал унтраагуурыг ажиллагаатай эсэхийг шалган ашиглахаар авч явна.

Эцэст нь дүгнэхэд энэхүү илтгэлд цагдаагийн байгууллагаас нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох тусгай ажиллагааны төлөвлөлтийн талаар авч үзсэн хэдий ч төрийн байгууллага, нэн ялангуяа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн нэгдсэн төлөвлөлтийг боловсруулах хэрэгцээ шаардлага одоо зүй ёсоор тавигдаж байгаад анхаарал хандуулах болсныг сануулж байна.

Мөн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг зохицуулах үүрэг бүхий субьектүүд дотроос иргэдтэй хамгийн ойр, тэдний дэргэд буюу хэрэг явдлын голомт дээр цагдаагийн байгууллага, түүний алба хаагчид ажилладаг бөгөөд ямар ч тохиолдолд хүч хэрэглэхээс зайлсхийх шаардлага тавигддаг бөгөөд төлөвлөлтийг энэхүү шаардлагад аль болохуйц нийцүүлэх нь чухал гэдэг нь тодорхой юм.

Үүний эцсийн үр дүн иргэдийн эрх, эрх чөлөөг бодитоор эдлүүлэх, тухайлбал нийгэм, улс төр, эдийн засгийн болон бусад чиглэлээр жагсаал, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ хуулийн хүрээнд эдлэх нөхцлийг бүрдүүлэхэд оршиж байна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*821 дүгээр дамжааны сонсогч.*
*цагдаагийн хошууч Н.Мөнх-Итгэл*

## ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Дэлхийн улс орнууд даяаршлын үйл явцад эрчимтэй шилжиж байгаа нь хүн төрөлхтний нийтлэг эрх ашгийн нэг томоохон дэвшил боловч, үүнийг дагасан сөрөг үр дагавар ихээр үүсэн бий болсоор байна.

Аюулгүй байдлын уламжлалт ойлголт хүрээгээ тэлж терроризм, халдварт өвчний тархалт, экологийн сүйрэл, байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол болон зэвсэг, хар тамхи, мансууруулах бодис, хүн худалдаалах гэх мэт үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг улам өсөн нэмэгдсээр байна. Дээрхи гэмт хэрэг, хууль бус үйлдэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн үед таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах нь дэлхийн улс орнууд төдийгүй манай улсын хэмжээнд тулгамдсан томоохон асуудлын нэг юм.

Сүүлийн жилүүдэд “терроризм[1]” гэх дэлхий нийтийг айдаст автуулсан шинэ нэр томъёо ихээр сонсогдох боллоо. Терроризм гэж “нийгмийн эсхүл

[1] Терроризмтой тэмцэх тухай Монгол Улсын хууль. 2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Их хурлаас баталсан. “3.1.1. дэх хэсэг. "терроризм” гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн